

**МОНГОЛ УЛСААС ГАРАЛ ҮҮСЭЛТЭЙ ЭКСПОРТЫН
БАРААНЫ ГАРАЛ ҮҮСЭЛ ТОДОРХОЙЛОХ,
ГАРАЛ ҮҮСЛИЙН ГЭРЧИЛГЭЭ ОЛГОХ,
БАТАЛГААЖУУЛАХ ЖУРАМ**

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1 Худалдаа Аж Үйлдвэрийн Танхимын тухай Монгол улсын хуулийн 6 дугаар зүйлийн 3-ийн бүрэн эрх гэсэн хэсэгт “ экспортын барааны гарал үүслийг гэрчилнэ “ хэмээн заасныг иш үндэс болгон Монгол улсаас гарал үүсэлтэй экспортын барааны гарал үүслийг тодорхойлох, гарал үүслийн гэрчилгээ олгох, баталгаажуулахад энэхүү журмыг мөрдлөг болгоно.
- 1.2 Эскпортын барааны гарал үүсэл тодорхойлох, гарал үүслийн гэрчилгээ олгох, баталгаажуулах үйл ажиллагааг Худалдаа Аж Үйлдвэрийн Танхимын тухай Монгол улсын хуулийн дагуу эрх олгосноор Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхим /цаашид Танхим гэнэ/ гүйцэтгэнэ.

Хоёр. Экспортын барааны гарал үүслийг тодорхойлох

2.1 Монгол улсаас гарал үүсэлтэй бараанд Монгол улсын бүрэн гарал үүсэлтэй бараа болон Монгол улсад явагдсан үйлдвэрлэлийн явцад үлэмж хэмжээний боловсруулалт орсон барааг тооцно.

2.2 Дор дурьдсан барааг Монгол улсын бүрэн гарал үүсэлтэй бараанд хамааруулна.

а/ Монгол улсын нутаг дэвсгэрээс олборлосон ашигт малтмал

б/ Монгол улсын нутаг дэвсгэрт ургасан ургамал болон түүнээс гаралтай бүтээгдэхүүн

в/ Монгол улсын нутаг дэвсгэрт төрж бойжсон амьд мал, амьтан, загас болон тэдгээрээс гаралтай бүтээгдэхүүн

г/ Монгол улсын хөлөг онгоцоор мөн түүнчлэн түрээслэн авсан хөлөг онгоцоор олборлосон далайн загас агнуурын болон далайн бусад бүтээгдэхүүн

д/ Монгол улсын хөвөгч загасны болон түрээслэн авсан хөвөгч загасны үйлдвэрт үйлдвэрлэсэн зөвхөн энэ зүйлийн /г/-д заасан бүтээгдэхүүн

е/ Монгол улсын нутаг дэвсгэрээс түүхий эд болгон ашиглахаар цуглуулсан урьд нь ашиглагдаж байсан эд зүйлс

ж/ Монгол улсад явуулсан үйлдвэрлэлийн хаягдал зүйлс

з/ Энэ зүйлийн е болон ж заалтанд дурьдагдсан зөвхөн тэдгээр зүйлсээс үйлдвэрлэлийн аливаа шатны боловсруулалт хийгдсэн бүтээгдэхүүн

2.3 Барааг үйлдвэрлэхэд нэгээс дээш орон хамрагдсан тохиолдолд уг бараа Монгол улсын нутаг дэвсгэрт үлэмж хэмжээний боловсруулалтанд орсон нөхцөлд түүнийг Монгол улсын гарал үүсэлтэй бараанд хамааруулна.

2.4 Үлэмж хэмжээний боловсруулалт гэсэн ойлголтод дараах шаардлагууд хамрагдана.

а/ Бараанд шинж чанарын буюу барааны уялдуулсан системийн хүрээнд өөрчлөлт гарсан байх

б/ Бараа үйлдвэрлэхэд зарцуулсан нэмүү өртгийн 40-ээс дээш хувийг Монгол улсад үйлдвэрлэсэн байх

2.5 Монгол улсын нутаг дэвсгэрт үлэмж хэмжээний боловсруулалт орсон барааны гарал үүслийг энэхүү журам болон тухайн импортлогч орны гарал үүслийн дүрмийн дагуу тодорхойлно.

2.6 Энэхүү журмын 2.2-т заасан шаардлагыг хангасан эсэхээс үл хамааран дараах ажилбарууд нь тухайн барааны гарал үүслийг тодорхойлох үндэслэл болохгүй

а/ тээвэрлэлт болон хадгалалтын явцад барааг хамгаалахын тулд тохиромжтой нөхцөлөөр хангах арга хэмжээ /агааржуулалт, хатаах, хөргөх, давслах гэх мэт/

б/ эсгэх, будах, угаах, ангилах, тоосноос цэвэрлэх гэх мэт энгийн хялбар үйлдлүүд

в/ савлалт, боодлыг өөрчлөх буюу савлагаа хийх хялбар хэлбэрүүд

г/ барааны шошго, тэмдэг зэрэг бусад ялгаварлах тэмдэгүүдийг наах, тогтоох

д/ эцсийн бүтээгдэхүүн болгохоор эд анги, хэсгүүдийг угсрах, холих энгийн хялбар үйлдлүүд

е/ энэ зүйлийн а-д дурьдсан үйлдлүүдийн хослол буюу нийлбэр үйлдлүүд

ж/ малын нядалгаа

2.7 Барааны гарал үүслийг тодорхойлох зорилгоор шаардлагатай тохиолдолд экспортлогчоор нэмэлт баримт бичиг гаргуулж, үйлдвэрлэлийн явц, байдалтай газар дээр нь танилцана.

2.8 Экспортын барааг тээвэрлэхэд гуравдагч орны нутаг дэвсгэрээр дамжин өнгөрөх тохиолдолд уг барааг тухайн орны нутаг дэвсгэрт байх хугацаанд тэр орны гаалийн хяналтан дор байлгана. Гуравдагч орны нутаг дэвсгэр дээр уг бараа нь арилжааны буюу үйлдвэрлэлийн үйл

ажиллагаанд өртөх бол энэ тухай гарал үүслийн гэрчилгээ авахаас өмнө мэдэгдсэн байвал зохино. Барааг дамжин өнгөрөх орон болон боомтыг гарал үүслийн гэрчилгээнд заана.

2.9 Үзэсгэлэн, яармагт явуулж байгаа барааны гарал үүслийг энэхүү журмын дагуу тодорхойлно. Үзэсгэлэн болох газрын хаяг, үргэлжлэх хугацааг гарал үүслийн гэрчилгээнд дурьдана.

Гурав. Гарал үүслийн гэрчилгээ олгох

3.1 Гарал үүслийн гэрчилгээ нь үнэт цаас мөн.

3.2 Гарал үүслийн гэрчилгээ нь Forma A буюу дэлхийн өндөр хөгжилтэй орнуудаас гаалийн татварын хөнгөлөлт эдэлдэг ба хөнгөлөлт эдэлдэггүй гэсэн хоёр төрөл байна.

3.3 Экспортлогчид барааны гарал үүслийн гэрчилгээг дараах тохиолдолд зайлшгүй авна.

- а/ Хөнгөлөлтийн Ерөнхий Системийн дагуу тухайн импортлогч орны гаалийн тарифын хөнгөлөлтөнд хамрагдах бараа
- б/ Олон улсын гэрээ, хэлэлцээр буюу бусад баримт бичигт энэ тухай дурьдсан байвал
- в/ Монгол улсаас бүрэн гарал үүсэлтэй бараа бүтээгдэхүүн
- г/ Монгол улсын нутаг дэвсгэрт үлэмж хэмжээний боловсруулалтанд орсон бараа бүтээгдэхүүн

3.4 Экспортын бараанд гарал үүслийн гэрчилгээ авахыг хүсэгч иргэн, аж ахуйн нэгж, хуулийн этгээд нь энэ журмын 1 дүгээр хавсралтанд заасан маягтын дагуу МҮХАҮТанхимд өргөдөл гаргана. Өргөдөлд дор дурьдсан зүйлийг заасан байвал зохино. Үүнд.

- өргөдөл гаргагчийн нэр, хаяг
- контракт болон нэхэмжлэхний дугаар, он, сар, өдөр
- барааны нэр, код /БТКУС/
- барааны тоо хэмжээ, гэрээнд заасан үнэ
- тээврийн төрөл маршрут
- хүрэх орон, боомт

Өргөдөлд дурьдсан мэдээллийн үнэн зөвийг өргөдөл гаргагч өөрөө хариуцна.

3.5 Гарал үүслийн гэрчилгээ олгох өргөдөлд дор дурьдсан бичиг баримтыг хавсаргасан байна.

- аж ахуйн нэгж, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар, хувь хүний хувьд иргэний үнэмлэхний хуулбар
- гэрээний хуулбар
- нэхэмжлэх
- сав баглаа боодлын хуудас
- давхар захиалгаар гүйцэтгүүлсэн ажлын тухай тодорхойлолт /subcontract/
- гарал үүслийн гэрчилгээний хураамжийн төлбөрийн баримт

3.6 Гарал үүслийн гэрчилгээг зөвхөн экспортлогч буюу түүний итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр дамжуулан бичгээр гаргасан өргөдлийн үндсэн дээр олгоно.

3.7 МҮХАҮТанхим нь гарал үүслийн гэрчилгээ олгох тухай өргөдөл, энэ зүйлийн 3.4-т заасан холбогдох баримт бичгийг хүлээн авснаас хойш ажлын нэг хоногт багтаан барааны гарал үүслийг тодорхойлж гэрчилгээ олгоно.

3.8 Монгол улсын олон улсын гэрээнд өөрөөр заагаагүй бол гарал үүслийн гэрчилгээний эх хувийг 210 x 297 мм хэмжээтэй энэхүү журмын 2 дугаар хавсралтын дагуу тусгай маягт бөглөн англи, франц буюу орос хэл дээр үйлдэнэ.

3.9 Гэрчилгээний эх хувийг үрэгдүүлсэн тохиолдолд түүний баталгаатай хувийг үйлдэж DUPLICATE тэмдэг дарна.

3.10 Гэрчилгээ бүрийг дугаарлана. Дугаарыг гэрчилгээний баруун дээд талд доорх жишгээр тавина.

- эхний хоёр үсэг нь MN буюу Монгол гэсний товчлол
- дараагийн хоёр үсэг нь импортлогч орны товчилсон нэр /улсын нэрийг олон улсын жишгээр товчилно/
- дараагийн нэг оронтой тоо нь тухайн оны сүүлчийн тоо /жишээ нь 2005 он гэвэл 5 гэж бичнэ./
- дараагийн тоо нь гэрчилгээний дугаар байна.

3.11 Гарал үүслийн гэрчилгээ олгоход Монгол улсын хууль тогтоомжинд заасны дагуу хураамж ногдуулна.

3.12 Монгол улсын экспортын барааны гарал үүслийн гэрчилгээнд МҮХАҮТанхимын дарга, түүний эзгүйд орлогч дарга гарын үсэг зурж Танхимын тусгай тамга дарна.

3.13 Гарал үүслийн гэрчилгээг бусдад шилжүүлэхийг хориглоно.

3.14 Гарал үүслийн гэрчилгээний хадгалалт, хамгаалалтыг экспортлогч өөрөө хариуцна.

3.15 Нууцын зэрэглэлд хамаарах буюу гарал үүслийн дүрмийг хэрэглэх зорилгоор нууцлах үндэслэлээр авсан бүх мэдээллийн нууцыг холбогдох байгууллагууд чанд сахина. Эдгээр мэдээллийг шүүх хуралдааны явцад задруулах шаардлага гарахаас бусад тохиолдолд түүнийг өгсөн этгээд буюу эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүйгээр задруулж үл болно.

Дөрөв. Гарал үүслийн гэрчилгээг баталгаажуулах

4.1 Импортлогч орны гаалийн байгууллагын хүсэлтээр гарал үүслийн гэрчилгээг дахин шалгах, баталгаажуулах ажлыг МҮХАҮТанхим гүйцэтгэж энэ талаарх санал, дүгнэлтийг тухайн гаалийн байгууллагад даруй мэдэгдэнэ.

4.2 Гарал үүслийн гэрчилгээг баталгаажуулах зорилгоор гарал үүслийн гэрчилгээний хуулбар болон түүнтэй холбогдох баримт бичгийг МҮХАҮТанхим гурван жилийн хугацаагаар хадгална.

4.3 Гарал үүслийн гэрчилгээ нь олгосон өдрөөс эхлэн нэг жилийн хугацаанд хүчинтэй.

Тав. Бусад зүйл

5.1 Барааны гарал үүслийг тодорхойлох, гарал үүслийн гэрчилгээ олгох, баталгаажуулахтай холбогдсон гомдлыг МҮХАҮТанхимын удирдлагад гаргана. Түүний шийдвэрийг эс зөвшөөрвөл холбогдох хууль тогтоомжийн дагуу шүүхэд хандаж болно.

5.2 Гарал үүслийн гэрчилгээг хуурамчаар үйлдсэн, худал мэдээлэл өгсөн, гарал үүслийг тодорхойлох, баталгаажуулах үйл ажиллагаанд саад учруулсан этгээдэд зохих хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

ХОЁРДУГААР БҮЛЭГ

Нэг. Гадаадын захиалагчийн материалаар
үйлдвэрлэх оёмол, сүлжмэл бүтээгдэхүүний
гарал үүслийг тодорхойлох

1.1 Монгол улсын гарал үүсэлтэй оёмол, сүлжмэл бүтээгдэхүүнд дараах барааг тооцно.

а/ Монгол улсын бүрэн гарал үүсэлтэй үс, ноос, ноолуур, бусад нэхмэлийн түүхий эдээр буюу тэдгээрээр хийсэн ээрмэл утас, даавуугаар Монгол улсад эсгэж, сүлжиж, оёх буюу өөр аргаар нийлүүлж эцсийн

бэлэн бүтээгдэхүүн болгож экспортонд нийлүүлэхээр савласан оёмол, сүлжмэл бүтээгдэхүүн

б/ Импортын гарал үүсэлтэй үс, ноос, ноолуур буюу нэхмэлийн бусад түүхий эдээр Монгол улсад утас болгон ээрч, сүлжиж бэлэн бүтээгдэхүүн болгож, савлаж АНУ-д экспортлох сүлжмэл бүтээгдэхүүн

в/ Импортын ээрсэн утсаар тухайн бүтээгдэхүүний үндсэн деталь хэсгүүдийг Монгол улсад сүлжиж харин бусад ажилбаруудыг өөр улсад гүйцэтгэж эцсийн бэлэн бүтээгдэхүүн болгон АНУ-д экспортлох сүлжмэл эдлэл. Энэ тохиолдолд бүтээгдэхүүний барааны тэмдэг нь Монгол улсад бүртгэгдсэн байна.

г/ Монгол улсад эсгэсэн эсвэл эсгэсэн деталь хэсгээр Монгол улсад оруулж ирсэн деталь хэсгүүдийг Монгол улсад оёж буюу өөр аргаар нийлүүлж савлаж эцсийн бэлэн бүтээгдэхүүн болгож АНУ-д экспортлох оёмол эдлэл

д/ Импортын гарал үүсэлтэй үс, ноос, ноолуур бусад нэхмэлийн түүхий эдээр буюу тэдгээрээр хийсэн ээрмэл утас, даавуугаар Монгол улсад эсгэж, сүлжиж, оёж буюу өөр аргаар нийлүүлж эцсийн бэлэн бүтээгдэхүүн болгож Европын Холбооны гишүүн орнуудад экспортлох оёмол, сүлжмэл эдлэл

1.2 Гадаадын захиалагчийн материалаар үйлдвэрлэсэн оёмол бүтээгдэхүүн дээр хийх наалт, хатгамал зэрэг гоёлын чимэглэлийг бүтээгдэхүүний эсгэсэн деталь хэсэг дээр наах, хатгах буюу өөр аргаар деталь хэсэгтэй холбосон байна.

1.3 Бусад оронд экспортлох оёмол, сүлжмэл бүтээгдэхүүний гарал үүслийг энэхүү журам болон тухайн импортлогч орны гарал үүслийн дүрмийн дагуу тодорхойлно.

Хоёр. Гадаадын захиалагчийн материалаар
үйлдвэрлэх оёмол, сүлжмэл бүтээгдэхүүний
гарал үүслийн гэрчилгээ олгох

2.1 Гадаадын захиалагчийн материалаар үйлдвэрлэх оёмол, сүлжмэл бүтээгдэхүүн экспортлогч нь экспортын контрактыг бүтээгдэхүүний эх загварын хамт Танхимд урьдчилан бүртгүүлнэ.

2.2 Гарал үүслийн гэрчилгээ авах бүтээгдэхүүний түүхий эд, даавуу, утас буюу эсгэсэн деталь Монгол улсын нутаг дэвсгэрт орж ирэх тухай бүрт

экспортлогч нь Танхимд даруй мэдэгдэж барааны гаалийн мэдүүлэг, нэхэмжлэх, сав баглаа боодлын бичиг баримтыг /англи хэл дээр/ Танхимд бүртгүүлнэ.

2.3 Гадаадын захиалагчийн материал нь гаалийн нутаг дэвсгэрт орж ирэх болон бэлэн бүтээгдэхүүн болон буцаж гарахад Танхимын төлөөлөгч нь гаалийн байцаагчтай хамтран бүрэн шалгалт хийнэ.

2.4 Танхим нь тухайн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн явцтай газар дээр нь танилцах эхний шалгалт хийнэ.

2.5 Бүтээгдэхүүн ачилтанд бэлэн болмогц экспортлогч нь энэ тухай Танхимд мэдэгдэж энэхүү журмын 3.2 дугаар заалтад дурьдсан өргөдөл болон холбогдох баримт бичгүүдийг Танхимд хүргүүлнэ.

2.6 Танхим нь дээрх бичиг баримтын үндсэн дээр ачилтын өмнөх дараагийн шалгалтыг хийж зөрчилгүй гэж үзсэн тохиолдолд гарал үүслийн гэрчилгээ олгоно.

2.7 Оёмол, сүлжмэл бүтээгдэхүүний экспорт эрхэлж буй этгээд экспортын мэдээг сар бүрээр дараа сарын 5-ны дотор 3 дугаар хавсралтанд заасан маягтын дагуу Танхимд гаргаж өгнө.

2.8 Гадаадын захиалагчийн материалаар үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг хилээр нэвтрүүлэхэд гаалийн байгууллага дараах эрх үүрэгтэй оролцоно.

а/ Бүтээгдэхүүний үндсэн ба туслах материалыг импортоор орж ирэх тухай бүр гаалийн бүртгэлд авсан байна.

б/ Тухайн барааг үйлдвэрлэхэд ашиглах зориулалтаар импортоор оруулж ирсэн үндсэн ба туслах материалын тооцоог хийсний үндсэн дээр гаалийн зохих журмын дагуу хилээр нэвтрүүлнэ.

в/ 2.1-р заалтанд хамрагдах барааг гарал үүслийн гэрчилгээгүй бол улсын хилээр нэвтрүүлэхгүй байх

г/ Барааны гарал үүслийг гаалийн байгууллага өөрөө тодорхойлохгүй, Танхимаас олгосон гарал үүслийн гэрчилгээг үндэслэнэ.

д/ Гаалийн байгууллагаас импортоор орж ирэх захиалагчийн материал, экспортод гарах бүтээгдэхүүнд хийх гаалийн үзлэг, шалгалт ба Танхимаас гарал үүслийг тодорхойлоход шаардагдах шалгалтын үйл ажиллагаа нь өөр хоорондоо уялдан зохицолдсон байна.

2.9 Энэхүү журмын нэгдүгээр бүлэгт тусгагдсан заалтууд энэ бүлэгт мөн хамаарна.

